

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### САЙНШАНД СУМЫН 7 ДУГААР БАГ 505, 511, 509, 509А БАЙРНЫ ГАДНА ТАЛБАЙН ТОХИЖИЛТЫН АЖИЛ

Сайншанд сум

2024.08.01

А. Ажил гүйцэтгэх хугацааны график хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоог тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

Б. Барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх

В. Үнийн саналд зураг төсвийн үнийг **1 535 000 /Нэг сая таван зуун гучин таван мянга/** төгрөгөөр, захиалагчийн хяналтын зардлыг талбайн угсралтын ажлын төсөвт өртгийн дүнгийн 2%-иар, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн хяналтын зардлын 50%-иар тооцож тусгаж ирүүлнэ.

Г. Төсөв зохиохдоо Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 30 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, төлөвлөгөөт ашиг, техник хяналт, нормчлолын сан, НӨАТ, магадлашгүй ажлын зардал зэргийг тооцож Барилгын төсөв зохиох дүрэм БНБД "Ү" 81-95-12-г мөрдлөг болгоно.

Д. Авто тээврийн зардлыг ЗТХС-ын 2022.08.22-ны өдрийн А/233 тоот тушаалаар батлагдсан жишиг тарифаар тооцно.

Е. ЗТХС-ын 2017 оны 212 дугаар тушаалаар машин механизмын зардлыг тооцож ирүүлнэ.

Ё. Үнийн тарифийг тооцон ирүүлэхдээ ажилбар тус бүрээр тооцож ирүүлнэ.

Ж. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах.

3. Газар шорооны ажлын хийж гүйцэтгэхийн өмнө геодези хэмжилтийн эрхтэй байгууллагаар шугам трассын дагуу улаан шугам тавиулж илд далд ажлын актыг баталгаажуулсаны дараа ажлын эхлүүлэх шаардлагатай. Улаан шугам тавиулах үед захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын төлөөллийг байцуулна.

#### 1. Талбайн газар шорооны ажил

Газар шороо болон суурийн ажлыг хийж гүйцэтгэхдээ БНБД 50-02-17г мөрдлөг болгон ажиллана. Талбайг бульдозероор тэгшлэн хийн тромбовкоор нягтруулна.

#### 2. Сүүдрэвч засах, Явган замын ажил

Дээврийг уян шинглас хар цаасаар бүрж модон хийцийг өнгийн тосон будгаар гар аргаар сайн чанартай будна. Явган хүний замын суурийг элс-хайрганы хольцоор хийж бетон хашлага угсарна. Тоглоомын талбайд явган замын өнгөт хавтан угсарна. Ажил гүйцэтгэх хугацаанд Барилга хот байгуулалтын сайдын 2017.11.30-ны 195 дугаар "Барилгын ажлын аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журам"-ыг баримтлан ажиллана.

### **3. Бетон талбай, Талбайн төмөр сараалжин хашааны ажил**

Бетон талбайн суурийг элс-хайрганы хольцоор хийж цемент бетон хольцоор зам талбайг гараар хийж/б=100см БМ-150/ 20мм зузаан цементэн тэгшилгээ хийнэ. Төмөр сараалжин хашаа, хаалга тосон будгаар 2 удаа будна.

### **4. Угсраа 58 айлын чийрэгжүүлэлтийн талбайн тохижилтын ажил**

Газар шороо болон суурийн ажлыг хийж гүйцэтгэхдээ БНБД 50-02-17г мөрдлөг болгон ажиллана. Талбайг бульдозероор тэгшлэн хийн тромбовкоор нягтруулна. Цемент бетон хольцоор зам талбайг гараар хийж/б=100см. БМ-150/, явган замд бетон хашлага хийж 20мм зузаан цементэн тэгшилгээ хийнэ.

### **5. Тоглоом суурилуулах ажил**

Хүүхдийн 2 урсгалтай гулсуур, хүүхдийн тоглоом/ дүүжин даажин/ турник/том жижиг/, гадна талбайн биеийн тамирын тоноглол/хөлний савлуур, дугуй, гэдэс таталт, эргэдэг диск/ угсарна. Гадна талбайд төмөр хөлтэй модон тавцантай сандал суурилуулна.

#### **Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:**

1. Талбайн угсралтын ажлыг батлагдсан төсөв, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.
4. Барилгын талбайд хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.
5. Талбайн угсралтын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
6. Барилгын тухай хуулийн 14.3-т заасны дагуу ашиглалтанд хүлээлгэн өгснөөс хойш зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна. Энэ хуулийн 14.6 заасны дагуу 14.3-т заасан хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.
7. Гүйцэтгэсэн ажлыг ил, далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.
8. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч тухайн ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.
9. Ажил гүйцэтгэж дууссаны дараа шугамын трассын дагуу геодези хэмжилтийн байгууллагаар гүйцэтгэлийн зураг гаргуулж ГХБХБГ-ын кадастрын мэдээллийн санд бүртгүүлнэ.

**ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ ХЯНАСАН:**

САЙНШАНД СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Д.ТӨМӨРБААТАР

**ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН:**

САЙНШАНД СУМЫН  
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР

*Б.Энхманлай*

Б.ЭНХМАНЛАЙ